



ХОТЫН СТАНДАРТ, ХЯНАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 09 сарын 28 өдөр

Дугаар А/НЗ

Улаанбаатар хот

Хотын стандартыг иргэд, олон нийтэд
сурталчилан таниулах арга хэмжээний тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 11/34, 2022 оны 18-26 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/851 дүгээр захирамж, Газрын дүрмийн 7.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Хотын стандартыг 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдүүлэх бэлтгэл арга хэмжээний төлөвлөгөөний хүрээнд Хотын стандартын талаар контент бэлтгэн олон нийтэд хүргэх ажлыг Хэвлэл, мэдээллийн байгууллагуудтай холбогдох хууль, тогтоомжийн дагуу хамтран зохион байгуулж ажиллахыг Худалдаа, үйлчилгээний стандартын хэлтэс (Н.Билэгсайхан)-т, Хот, нийтийн аж ахуйн стандартын хэлтэс (О.Оджаргал)-т тус тус үүрэг болгосугай.

2. Контент боловсруулах үйл ажиллагаанд шаардагдах 13,200,000 (Арван гурван сая хоёр зуун мянга) төгрөгийг Бусдаар гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний зардлаас санхүүжүүлэхийг Ахлах нягтлан бодогч (Б.Түмэнжин)-д зөвшөөрсүгэй.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар ханган ажиллахыг Захиргааны хэлтэс (Э.Даваахатан)-т даалгасугай.

ДАРГА



С.ТӨМӨРДУЛАМ